



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2023.11.29. № 3г-1/161

танай _____-ны № _____-г

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000234004023



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023.09.29 № ХЯТ/дс91
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт *дс* хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 38 дугаар тэмдэглэлд:

"II.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр.
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.09.27 № 01/7144

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг олгож байна.

Хавсралт: 01 хуудас.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761002136



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mjha.gov.mn,

Цахим хуудас: www.mjha.gov.mn

2023.09.26 № 1/4920

танай 2023.09.22-ны № 01/7055 -т

**САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

151604309



**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**

Энхтайваны өргөн чөлөө 7а,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27,
Цахим шуудан: info@mfa.gov.mn,
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2023.09.24 № 09/5052
танай _____-ны № 01/7055 -т

САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9-д заасны дагуу Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгов.



Б.БАТЦЭЦЭГ

115231088

БАТЛАВ.
САНГИЙН САЙД



Б.ЖАВХЛАН

БАТЛАВ.
ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН САЙД



С.БЯМБАЦОГТ

БАТЛАВ.
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЙД



Х.БОЛОРЧУЛУУН

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН
ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД



Ч.ХҮРЭЛБААТАР

БАТЛАВ.
ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД



Б.БАТЦЭЦЭГ

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД



Х.НЯМБААТАР

**МОНГОЛ УЛС, ДЭЛХИЙН БАНКНЫ ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ,
ХӨГЖЛИЙН БАНК БОЛОН ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ
ХООРОНДЫН "МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН ХОЛБОЛТ БОЛОН
ЛОГИСТИКИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ"-ИЙН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл,
шаардлага**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны 56 дугаар тэмдэглэл, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаан, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 19, 27-ны өдрийн хуралдааны санал, дүгнэлт болон Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр захирамжийг үндэслэн Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрт Сангийн сайд Б.Жавхлан 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр гарын үсэг зурсан.

Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь хэсэгт заасны дагуу гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ тул Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай юм.

Хоёр.Хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд тээвэр, логистикийн дэд бүтцийн сүлжээг сайжруулан, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээний алдагдлыг бууруулах чухал ач холбогдолтой юм.

Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай, Хууль тогтоомжийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлэх бөгөөд хуулийн төсөлтэй уялдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй болно.

Товч танилцуулга

Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

1. Ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, зарчмын шинжтэй зохицуулалт:

Уг хуулийн төсөл нь 1 зүйлтэй.

Хуулийн төсөлд Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Энэхүү "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасан "гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ"-нд хамаарах тул Улсын Их Хурал соёрхон батлах хуулийн зохицуулалттай болно.

2. Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал:

Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах харилцаа тул тус харилцааг урьд нь хууль, эрх зүйн актаар зохицуулаагүй болно.

3. Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Төслийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тус төслийн Зээлийн хэлэлцээрийг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр хийсэн.

4. Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн:

Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаан, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлэн, зөвшилцсөний үндсэн дээр байгуулсан болно.

5. Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт:

Уг хуулийн төсөлд тусгасан Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Монгол Улсын тээврийн холболт болон

логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийн хүрээнд Дэлхийн банкнаас Ерөнхий нөхцөлийн гарын авлага болон хэрэгжүүлэхтэй холбоотой бусад судалгааг хийсэн.

Дэлгэрэнгүй танилцуулга

Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

1. Зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай:

Уг хуулийн төсөл нь 1 зүйлтэй.

Хуулийн төсөлд Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Энэхүү "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасан "гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ"-нд хамаарах тул Улсын Их Хурал соёрхон батлах хуулийн зохицуулалттай болно. /Төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг хавсаргав/.

*"Монгол Улсын тээврийн холболт болон
логистикийг сайжруулах төсөл"-ийн тухай*

1. Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

1.1. Төслийн хэрэгцээ шаардлага:

Монгол Улс логистикийн гүйцэтгэлийн индексийн үзүүлэлтээр 138 орноос 97 дугаар байранд, дэд бүтцийн үзүүлэлтээр 108 дугаарт, логистикийн үйлчилгээний үзүүлэлтээр 119 дүгээр байранд тус тус жагсаж байгаа нь Монгол Улсын тээвэр, логистикийн салбарыг хөгжүүлэх зайлшгүй шаардлага үүссэнийг харуулж байна.

Түүнчлэн, Монгол Улс дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогод хөдөө аж ахуй, аялал жуулчлал, аж үйлдвэржилт болон сэргээгдэх эрчим хүчийг эдийн засгийн хөдөлгөгч хүч байхаар тодорхойлсон хэдий ч Монгол Улсын хувьд эдгээр салбарын өрсөлдөх чадварыг сайжруулахад тээвэр, логистикийн асуудал томоохон бэрхшээл хэвээр байна.

Дэлхийн банкны санхүүжилтээр "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийг хэрэгжүүлснээр авто замын сүлжээний бэлэн байдал, тээвэр, логистикийн дэд бүтцийн сүлжээ сайжирч, салбаруудын өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэн, эцсийн хэрэглэгчдэд хямд өртгөөр шинэ бүтээгдэхүүнийг хүргэх боломжийг олгох юм.

Тус төслийн зээлийн хэлэлцээрийг зөвшилцөх асуудлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороод 2022 оны 12 дугаар сарын 13, 19, 27-ны хуралдаанаараа хэлэлцсэн. Байнгын хороодын хуралдаанаар зээлийн хэлэлцээрийн төсөлд туссан зарим ажлууд ач холбогдол бага, үр ашиггүй байгааг анхааруулан, логистикийн төв байгуулахад зарцуулах санхүүжилтийг зам засварын ажилд зарцуулах нь зүйтэй гэсэн саналыг гаргасан. Мөн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс шинэчлэх, засвар хийх улсын чанартай авто замын нарийвчилсан тооцоог гаргаж, бүсийн тээврийн логистикийн нэгдсэн авто замын сүлжээг байгуулахад анхаарах талаар дурдсан.

Байнгын хороодоос өгсөн саналыг дагуу Зам, тээврийн хөгжлийн яам болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран ажилласан. Тус төслийн хэрэгжүүлэгч Зам, тээврийн хөгжлийн яамнаас төслийн бүрэлдэхүүн хэсгийн 2.1-д тусгагдсан "Бүсийн жишиг логистикийн төв" байгуулах ажлын санхүүжилтийг авто замын засвар, арчлалтын ажилд зарцуулах хүсэлтийг ирүүлсэн. Тус хүсэлтийн дагуу Дэлхийн банк болон Зам, тээврийн хөгжлийн яамтай хамтран ажиллаж, төслийн санхүүжилтийг дэд бүтцийн ажилд чиглүүлэх буюу төслийн хүрээнд авто замын ээлжит болон их засвар хийхээр төлөвлөн, зээлийн хэлэлцээрт өөрчлөлт оруулсан бөгөөд зээллэгийн үндсэн нөхцөлд өөрчлөлт ороогүй болно.

1.2. Төслийн зорилго, ач холбогдол:

"Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийг хэрэгжүүлснээр уул уурхайн салбарын үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай

эдийн засгийг төрөлжүүлэх, тээвэр, логистикийн дэд бүтцийн сүлжээг сайжруулан, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээний алдагдлыг бууруулах чухал ач холбогдолтой юм.

Тодруулбал Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар авто замын нөхцөлийг сайжруулснаар зорчиж буй тээврийн хэрэгслийн зорчих хугацааг дунджаар 0.27-0.58 цагаар богиносгож, нүүрсхүчлийн хийн ялгаралтыг 17,585 тонноор бууруулах байна.

2. Төслийн зээлийн хэмжээ, нөхцөл, хамрах хүрээ

Төсөл хэрэгжүүлэгч: Зам, тээврийн хөгжлийн яам

Төсөл хэрэгжих хугацаа: 2023 он–2026 он /4 жил/

“Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл” нь нийт 110 сая ам.долларын төсөвт өртөгтэй бөгөөд Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (ОУСБХБ)-аас олгох 100 сая ам. долларын зээл нь жилийн Баталгаат овернайт хүүгийн түвшин /SOFR/¹ дээр 1.30 хувийн нэмэгдэл бүхий хувьсах хүүтэй, 5 жилийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 25 жилийн хугацаанд зээлийн эргэн төлөлтийг хийх нөхцөлтэй.

Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)-аас олгох 7.3 сая зээлжих тусгай эрх (10 сая орчим ам.доллар) нь ОУХА-аас олгох зээл нь жилийн 2 хувийн тогтмол хүүтэй, 5 жилийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 25 жилийн хугацаанд зээлийн эргэн төлөлтийг хийх нөхцөлтэй болно.

3. Бодлогын баримт бичигт туссан байдал

“Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл” нь төрөөс хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн дараах бодлогын баримт бичгүүдэд туссан байна. Үүнд:

- Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн Зорилт 3.4-т “Экспортын ач холбогдол бүхий түүхий эд, бүтээгдэхүүний нэгдсэн агуулах болон тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулсан байна.” гэж;
- “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:
 - Зорилт 8.1.4-т “Олон улсын болон бүсийн тээвэр логистикийн нэгдсэн сүлжээг үе шаттай барьж байгуулж, хөрш орнуудын сүлжээтэй холбогдсон байна.” гэж;
 - Зорилт 8.2.4-т “Орон нутгийн тээвэр логистикийн нэгдсэн сүлжээг үе шаттайгаар байгуулж, олон улсын болон бүсийн тээвэр логистикийн сүлжээнд холбосон байна” гэж;
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 8.1.1-д “Өрнө-Дорнын бүсийн орнуудыг холбох дэд бүтцийн хөндлөн гол тэнхлэгийн авто зам болон хойд, урд хөршийг холбох зарим бүсийн босоо тэнхлэгийн авто замыг барьж худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох суурь нөхцөлийг бүрдүүлсэн байна.” гэж;

¹ Secured Overnight Financing Rate буюу баталгаат овернайт санхүүжилтийн хүү.

- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.6.1-д “Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.” гэж тус тус заасан байна.

4. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцсэн байдал

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т заасны дагуу Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа нь 2023 онд 65 хувь, 2024 оноос эхлэн 60 хувиас хэтрэхгүй байхаар тус тус хуульчлагдсан.

Энэ хүрээнд 2023-2024 оны хооронд эдийн засаг харгалзан 6.0 хувь, 7.0 хувиар өсөж, Монгол Улсын 2023 оны төсөв, 2024-2025 оны төсвийн төсөөлөлд тусгагдсан гадаад зээлийн хөрөнгийг авч ашиглах тохиолдолд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2023 онд 44.3 хувь, 2024 онд 42.7 хувьтай тус тус тэнцэхээр тооцоологдсон. Ингэснээр эдгээр онуудад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангахаар байна.

5. Төслийн хүрээнд хийгдэх ажил, хүлээгдэж буй үр дүн

5.1. Ээлжит болон их завсар хийх зам:

“Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд ээлжит болон их завсар хийх шаардлагатай авто замын чиглэлийг ачаа, тээврийн урсгал, төвийн тээвэрлэлтийн нэгдсэн сүлжээтэй холбогдох холболт болон Олон улсын хучилтын тэгш байдлын индекс $IIRI^2$ -ийн үзүүлэлттэй уялдуулах юм. Авто замын ээлжит болон их засварыг хийхээс гадна замын зорчих хэсгийг засварлах, шинэчлэх, ус зайлуулах сувгийг сайжруулах, авто замын тэмдэг, тэмдэглэгээ, зэрлэг ан амьтдын гарц зэрэг замын хөдөлгөөний аюулгүй байдлын байгууламжийг байгуулах юм. Түүнчлэн, төслийн хүрээнд ээлжит засвар хийгдэх авто замд зураг төсөв шаардлагагүй бөгөөд их засвар хийгдэх, зураг төсөвтэй авто замын барилгын ажлыг 2024 оны хавар эхлүүлэхээр төлөвлөөд байна.

Дээрх авто зам засварын ээлжит болон их засварыг хийж, авто замын зорчих нөхцөл сайжирснаар тээврийн хэрэгслийн ашиглалтын зардал, зорчих цаг болон зам тээврийн ослыг бууруулах замаар нөлөөлөлд өртөж буй зорчигчдод эдийн засгийн ихээхэн үр өгөөжтэй буюу уг төслийн эдийн засгийн дотоод өгөөж 18.7 хувь байна.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн саналыг үндэслэн тэргүүн ээлжид Улаанбаатар-Арвайхээр, Хархорин-Цэцэрлэг, Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн автозамуудын ээлжит болон их засварын ажил, Улаанбаатар-Өндөрхаан, Булган-Мөрөн, Арвайхээр-Баянхонгор, Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн автозамын их засварын ажил болон төмөр бетон гүүрийн их болон ээлжит засварын ажлыг тус төслийн хүрээнд хийхээр төлөвлөсөн болно.

² Тус индекс нь авто замын тэгш байдлыг уртын дагуу хэмждэг Дэлхийн стандарт бөгөөд ачааны урсгал ихээр төвлөрсөн авто замын гол хэсгүүдэд шаардлагатай ажил, цар хүрээг тодорхойлдог болно.

5.2. Техник туслалцаа:

Авто замын сүлжээний хөрөнгийн менежментийг боловсронгуй болгох, хууль, эрх зүйн орчныг сайжруулах, дэвшилтэт программ хангамж нэвтрүүлэх, боловсон хүчнийг чадавхжуулах стандарт, зах зээлийн судалгаа хийх, норм нормативыг сайжруулах, шинэчлэхэд чиглэгдэх юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

ЗЭЭЛИЙН ДУГААР 9336-MN

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

(Монгол Улсын тээврийн сүлжээ, логистикийг сайжруулах төсөл)

МОНГОЛ УЛС

болон

ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНКНЫ

хооронд байгуулсан

Монгол Улсын Сангийн яам
АЛБАН ЕСНЫ ОРЧУУНГА МСД

Гарын үсэг /Signature/ *u*

2023 оны 08 сарын 28 өдөр
Няанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү Зээлийн хэлэлцээрийг, МОНГОЛ УЛС (цаашид “Зээлдэгч” гэх) болон ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК (цаашид “Банк” гэх)-ны хооронд дор гарын үсэг зурсан өдөр байгуулав.

Зээлдэгч нь энэ Хэлэлцээрийн Хуваарь 1-д заасан төсөл (цаашид “Төсөл” гэх)-ийг хэрэгжүүлэх санхүүжилтийн туслалцаа үзүүлэхийг Ассоциациас хүссэн бөгөөд Ассоциаци нь Зээлдэгч болон Ассоциаци хооронд мөн өдөр байгуулсан санхүүжилтийн хэлэлцээр (“Санхүүжилтийн хэлэлцээр”)-ийг үндэслэн долоон сая гурван зуун мянган Зээлжих тусгай эрх (ЗТЭ 7,300,000)-ийн зээл олгохоор тохиролцов.

ИЙМД, Зээлдэгч болон Банк хооронд дараах зүйлийг тохиролцов:

ЗҮЙЛ I — ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ; НЭР ТОМЬЁО

- 1.01. Ерөнхий нөхцөл нь (энэхүү Хэлэлцээрийн Хавсралтад тодорхойлсон) уг Хэлэлцээрийн салшгүй нэг хэсэг мөн.
- 1.02. Агуулга нь өөрөөр заагаагүй бол энэхүү Хэлэлцээрт том үсгээр тэмдэглэсэн нэр томьёо нь Ерөнхий нөхцөл эсвэл Санхүүжилтийн хэлэлцээрт тодорхойлсон утгаар ойлгоно (үүнд Хэлэлцээрийн оршил хэсэг, хавсралтууд багтана).

ЗҮЙЛ II — ЗЭЭЛ

- 2.01. Банк нь Зээлдэгчид төслийг санхүүжүүлэх зорилгоор нэг зуун сая (100,000,000) ам.долларын зээл (цаашид “Зээл” гэх) олгохыг зөвшөөрөв, энэ үнийн дүнг Валют хөрвүүлэгчээр тухайн цагт нь хөрвүүлж болно.
- 2.02. Зээлдэгч нь энэ Хэлэлцээрийн Хуваарь 2-ын Хэсэг III-т заасны дагуу Зээлийн хөрөнгийг татан авч болно.
- 2.03. Үйлчилгээний хураамж нь зээлийн дүнгийн нэг хувийн дөрөвний нэг (0.25%)-тэй тэнцүү байна.
- 2.04. Зээлийн хөрөнгийн ашиглагдаагүй үлдэгдэлд Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг жилд нэг хувийн дөрөвний нэг (0.25%)-тэй тэнцүү байна.
- 2.05. Хүүний хэмжээ нь Лавлах суурь хүү дээр Хувьсах хүүг нэмсэнтэй тэнцүү байх буюу Ерөнхий нөхцөлийн 3.02(e) хэсэгт заасны дагуу хөрвүүлсний дараа ашиглаж болох хувь хэмжээ байна.
- 2.06. Төлбөр гүйцэтгэх өдөр нь жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдөр болон 9 дүгээр сарын 15-ны өдөр байна.
- 2.07. Зээлийн үндсэн төлбөрийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 3-т заасны дагуу хийнэ.

Монгол Улсын Сангийн яам
САНХҮҮЖИЛТИЙН ОРЧУУЛГА БО

и үсэг /signature/

2023 оны 08 сарын 29 өдөр
Гармбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

ЗҮЙЛ III — ТӨСӨЛ

- 3.01. Зээлдэгч нь Төслийн зорилгыг хангах үүрэг хүлээж байгаагаа үүгээр мэдэгдэж байна. Үүнтэй холбогдуулан, Зээлдэгч нь Ерөнхий нөхцөлийн Зүйл V заалтууд болон энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-т заасны дагуу Төслийг ЗТХЯ-аар дамжуулан хэрэгжүүлнэ.

ЗҮЙЛ IV — ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ЦУЦЛАХ

- 4.01. Хүчин төгөлдөр болоход дараах Нэмэлт нөхцөлийг хэрэгжүүлнэ:
- (a) Зээлдэгч нь ЗТХЯ-аар дамжуулан Төслийн үйл ажиллагааны гарын авлагыг Банкны хүлээн зөвшөөрсөн хэлбэр, агуулгаар баталсан байна; мөн
 - (b) Зээлдэгч нь ЗТХЯ-аар дамжуулан Төсөл хэрэгжүүлэх нэгжийг Банкны шаардлагад нийцсэн чиг үүрэг, бүрэлдэхүүн, нөөц, ажлын удирдамжтайгаар байгуулсан байна;
 - (c) Санхүүжилтийн хэлэлцээрийг байгуулж хүргүүлсэн байх бөгөөд түүнд заасан тухайн хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох, эсвэл, тухайн хэлэлцээрийн дагуу Зээлдэгчийн зээлийн хөрөнгө татан авах эрх (энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр болохтой холбоотой заалтаас бусад)-тэй холбоотой бүх нөхцөл биелсэн байна.
- 4.02. Хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш зуун наян (180) хоног байна.
- 4.03. Ерөнхий нөхцөлийн 9.05 (b) хэсгийн хувьд, Зээлдэгчийн энэхүү Хэлэлцээрээр хүлээсэн үүрэг (төлбөрийн үүргээс бусад) дуусгавар болох огноо нь Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш хорин (20) жил байна.

ЗҮЙЛ V— ТАЛУУДЫН ТӨЛӨӨЛӨЛ; ХАЯГ

- 5.01. Зээлдэгчийн төлөөлөгч нь санхүүгийн асуудал эрхэлсэн Сайд байна.
- 5.02. Ерөнхий нөхцөлийн 10.01-д заасан зорилгоор,

(a) Зээлдэгчийн хаяг нь:

Сангийн яам
Засгийн газрын II-р байр
С.Данзангийн гудамж 5/1 Д
Улаанбаатар 15160
Монгол Улс;

(б) Зээлдэгчийн цахим хаяг нь:

Факс:



976-11-3202472

5.03. Ерөнхий нөхцөлийн 10.01-д заасан зорилгоор,

(а) Банкны хаяг нь:

Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк
1818 Н гудамж, N.W.
Вашингтон, ДС 20433
Америкийн Нэгдсэн Улс;

(б) Банкны цахим хаяг нь:

Телекс: Факс:
248423(MCI) эсвэл 1-202-477-6391
64145(MCI)



Гарын үсэг зурсан өдрийн байдлаар ТОХИРОЛЦОВ.

МОНГОЛ УЛС

_____ Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____

**ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ,
ХӨГЖЛИЙН БАНК**

_____ Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____



ХУВААРЬ 1

Төслийн танилцуулга

Төслийн зорилго нь зам, тээврийн биет холболтыг сайжруулах замаар Монгол Улсын махны өртгийн сүлжээний логистикийн үр ашгийг дээшлүүлэхэд оршино.


Төсөл нь дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

Бүрэлдэхүүн хэсэг 1. Дэд бүтцийн хөрөнгө оруулалт

- 1.1. Стратегийн ач холбогдолтой авто замын сүлжээний гол хэсгүүдэд үр дүнд-суурилсан засвар, арчлалт хийх. Сонгогдсон аймгуудад улсын чанартай авто замын сүлжээний 361 км орчим хэсгийн засвар, шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 1.2. Малчдыг холбох орон нутгийн зам. Сонгогдсон аймгуудад 51 км орон нутгийн чанартай замыг шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 1.3. Авто замын үндсэн хөрөнгийн менежмент. Энэ хүрээнд, (i) авто замын дэд бүтцийн хөрөнгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох; (ii) уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлын одоогийн техникийн стандарт, шаардлагуудыг шинэчлэхэд техникийн дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 2. Логистикийн үйлчилгээ

- 2.1. Логистикийн төвүүдийн техник эдийн засгийн үндэслэл. Логистикийн төвүүдийн техник эдийн засгийн үндэслэл болон мастер төлөвлөгөөг боловсруулахад техникийн туслалцаа болон чадавхыг бэхжүүлэх дэмжлэг үзүүлнэ.
- 2.2. Логистик ба нийлүүлэлтийн сүлжээний платформу. Нийлүүлэлтийн сүлжээг цахимжуулах платформыг хөгжүүлэхэд техникийн болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүлнэ, үүнд: (i) платформын өгөгдөл болон түүний үзүүлэх үйлчилгээг тодорхойлохын тулд махны нийлүүлэлт, логистикийн сүлжээнд оролцогч талуудад тулгарч буй хүндрэлтэй асуудлын судалгаа хийх замаар, хийдэл буюу эрэлтийн шинжилгээ хийх; (ii) платформын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох; (iii) логистикийн байгууллагууд болон малчид, тэр дундаа эмэгтэй удирдлагатай малчдад платформд оролцох цахим хэрэгсэл, ур чадвар, мэдлэгээр дэмжих.
- 2.3. Нийлүүлэлтийн сүлжээнд инноваци нэвтрүүлэх туршилтын төслүүд. Логистикийн үйл явц, тээврийн маршрутын цахим нэгтгэл хийхэд ашиглах, тухайлбал, хүргэлтийг бодит цагт шууд хянадаг; агуулах, ухаалаг ачааны машин, чингэлэг; байгаль орчин, амьтдын мониторинг хийх зориулалтын зүйлсийн интернэт мэдрэгчүүдийг холбож, нэгтгэх зэрэг программууд орно.
- 2.4. Гэрээт логистик үйлчилгээний дүрэм журам, стандарт. Логистикийн үйлчилгээг зохицуулсан дүрэм журмыг шинэчлэхэд техникийн дэмжлэг үзүүлнэ.



Бүрэлдэхүүн хэсэг 3. Техникийн туслалцаа ба чадавхыг бэхжүүлэх

- 3.1. Махны экспортын тээвэр ба логистикийн стратегийн судалгаа. Терминалын үйлчилгээ, интермодал үйл ажиллагаа, экспортын логистикийн бизнесийг хөгжүүлэх зэргийг багтаасан экспортын логистикт зориулсан төмөр зам, агаарын тээврийн логистикийн стратегийн судалгааг хийнэ.
- 3.2. Төслийн менежмент, техникийн судалгаа ба чадавхыг бэхжүүлэх. Энэ хүрээнд, (а) сонгосон зам, гүүрийн техникийн зураг төсөл, санхүүгийн менежмент ба зарцуулалт, худалдан авах ажиллагаа, байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн менежмент, олон нийтийн хэлэлцүүлэг, оролцоо, хяналт, тайлагналт, үнэлгээ; (б) замын хөрөнгийг удирдах, логистикийн гэрээт үйлчилгээг зохицуулах, төр-хувийн хэвшлийн түншлэлд хяналт тавих чадавхыг бэхжүүлэхэд техникийн болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүлнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 4. Болзошгүй онцгой байдлын үед авах харну арга хэмжээ

Шаардлагатай тохиолдолд онцгой гэж зөвшөөрөгдөхүйц нөхцөл байдалд яаралтай харну арга хэмжээ авах.



ХУВААРЬ 2

Төслийг хэрэгжүүлэх

Хэсэг I. Төсөл хэрэгжүүлэх зохицуулалт

A. Институтийн зохион байгуулалт.

1. Зээлдэгч нь Төслийн үйл ажиллагааны гарын авлагад тусгасны дагуу төслийг хэрэгжүүлэх хугацаанд улс, орон нутгийн түвшинд Банкны шаардлагад нийцсэн бүтэц бүрэлдэхүүн, чиг үүрэг, орон тоо, нөөц бүхий Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулж ажиллуулна.
2. Зээлдэгч нь дээр дурдсанаар хязгаарлагдахгүйгээр:
 - (a) Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг (1) сарын дотор ЗТХЯ, ХХААХҮЯ, ЭЗХЯ, ЗТХТ, төсөлд хамрагдахаар сонгогдсон аймгийн захиргаа болон СЯ-ны төлөөллөөс бүрдсэн, ЗТХЯ-аар ахлуулсан Төслийн удирдах хороог байгуулах бөгөөд Төслийн удирдах хороо нь Төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах үүрэг хүлээнэ.
 - (b) ЗТХЯ-ны дэргэд байгуулагдах Төсөл хэрэгжүүлэх нэгж нь (i) Жилийн ажлын төлөвлөгөө, улирлын тайлан бэлтгэх, (ii) худалдан авах ажиллагаа, санхүүгийн менежмент, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежмент болон гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэх; (iii) Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээ зэргийг багтаасан төслийн өдөр тутмын хэрэгжилтийг хариуцаж ажиллах үүрэг хүлээнэ.

B. Төслийн үйл ажиллагааны гарын авлага.

Зээлдэгч нь ЗТХЯ-аар дамжуулан Төслийн үйл ажиллагааны гарын авлага (ГҮАГА)-д тусгасан зохицуулалт, журмын дагуу төслийг хэрэгжүүлэх (ГҮАГА болон энэ Хэлэлцээрийн заалтууд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Хэлэлцээрийн заалтуудыг дагаж мөрднө) бөгөөд Банк урьдчилан бичгээр зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд ГҮАГА-ын аливаа зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оруулах, татгалзах, зайлсхийх үйлдэл гаргаж үл болно.

C. Жилийн ажлын төлөвлөгөө, төсөв.

1. Зээлдэгч нь ЗТХЯ-аар дамжуулан Төслийг хэрэгжүүлэх хугацаанд (эсвэл Банкны сүүлд зөвшөөрсөн хугацаанд) дараагийн санхүүгийн жилд төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгож буй төслийн бүх үйл ажиллагаа, зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж, энэ Хуваарийн Хэсэг D-д заасан байгаль орчин, нийгмийн хариуцлагын чиглэлээр авч хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг багтааж нэгтгэсэн жилийн ажлын төлөвлөгөө болон төсвийг бэлтгэж санхүүгийн жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор зөвшөөрөл авахаар Банканд хүргүүлнэ.
2. Зээлдэгч нь Төслийг Банкнаас хүлээн зөвшөөрсөн тухайн жилийн ажлын төлөвлөгөө болон төсөвт заасны дагуу хэрэгжүүлэх бөгөөд ингэхдээ ЖАТТ



болон энэ Хэлэлцээрийн заалтууд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Хэлэлцээрийн заалтуудыг дагаж мөрдөнө.

3. Зээлдэгч нь Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр ЖАТГ-т ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй, бусад этгээд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх ёсгүй.

D. Байгаль орчин, нийгмийн стандартууд.

1. Зээлдэгч нь төслийг байгаль орчин, нийгмийн стандартад нийцсэн, Банканд хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
2. Зээлдэгч нь дээрх I дэх зүйлд зааснаар хязгаарлагдахгүйгээр, төслийг Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө (БОНХТ)-ний дагуу Банканд хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар хэрэгжүүлнэ. Үүний тулд, Зээлдэгч нь дараах нөхцөлийг бүрдүүлнэ. Үүнд:

(a) БОНХТ-нд тусгагдсан арга хэмжээ, үйл ажиллагаанд БОНХТ-ний дагуу магадлан шалгалт хийж, үр дүнтэй хэрэгжүүлэх;

(b) БОНХТ-г хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын санхүүжилт хангалттай байх;

(c) БОНХТ-нд тусгасан бодлого, дүрэм, журмыг сахин мөрдөж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хангалттай тооны мэргэшсэн, туршлагатай ажилтантай байх;

(d) БОНХТ-нд заасны дагуу Банктай өөрөөр бичгээр тохиролцооноос бусад тохиолдолд БОНХТ, эсвэл түүний аливаа заалтыг өөрчлөх, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, татгалзахгүй байх, БОНХТ-г шинэчлэгдмэгц энэ талаар олон нийтэд зохих ёсоор мэдээлэх.

3. БОНХТ болон энэхүү Хэлэлцээрийн заалт хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Хэлэлцээрийн заалтыг баримтална.

4. Зээлдэгч нь дараах шаардлагыг хангасан байна:

(a) Тогтмол гаргах тайланг БОНХТ-нд заасан давтамжтайгаар цуглуулах, нэгтгэн бэлтгэж Банканд хүргүүлэхэд шаардагдах бүхий л арга хэмжээг авах, Банкнаас БОНХТ болон түүний байгаль орчин, нийгмийн хамгааллын хэрэгслүүд бодит нөхцөл байдалтай нийцэж байгаа эсэх талаар мэдээлэл хүссэн тохиолдолд, энэ тухай мэдээллийг даруй цуглуулж, нэгтгэн Банканд хүргүүлэх ба бүх тайланг хэлбэр, агуулгын хувьд Банк хүлээн зөвшөөрөхүйц байдлаар бэлтгэнэ. Тухайлбал, (i) БОНХТ-ний хэрэгжилтийн төлөв байдал; (ii) Хэрэв үүссэн бол, БОНХТ-г хэрэгжүүлэхэд саад учруулсан эсвэл саад учруулахаар заналхийлсэн нөхцөл байдал; (iii) ийм нөхцөл байдлыг засаж залруулах талаар авсан эсвэл авах шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх тусдаа тайланг бэлтгэнэ.

(b) Төсөлтэй холбоотой, эсвэл төсөлд нөлөөлсөн, нөлөөлж болзошгүй аливаа онцгой тохиолдол, осол, БОНХТ, түүнд дурасан байгаль орчин, нийгмийн арга хэрэгсэл, Байгаль орчин, нийгмийн стандартаар байгаль орчинд үзүүлсэн мэдэгдэхүйц сөрөг нөлөөлөл, нөлөөлд өртсөн олон нийт, эсвэл ажилтнуудын талаар Банканд нэн даруй мэдэгдэнэ.



5. Зээлдэгч нь нөлөөлөлд өртсөн хүмүүсийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Гомдол барагдуулах хүртээмжтэй механизмыг бий болгож, сурталчилж, ажиллуулах ба аливаа санал гомдлыг Банканд хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар шийдвэрлэх, шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай бөгөөд үүний тулд зүй зохистой бүхий л арга хэмжээг авна.
6. Зээлдэгч нь тендерийн сонгон шалгаруулалтын бүх бичиг баримт, төслийн хүрээнд хийгдэх барилгын ажлын гэрээнд гүйцэтгэгчид, туслан гүйцэтгэгчид болон хяналт тавих байгууллагуудын (а) БОНХТ-ний холбогдох заалтууд, түүнд дурдсан байгаль орчин, нийгмийн хариуцлагыг биелүүлж ажиллах; (б) дээрх гэрээний дагуу захиалсан эсвэл гүйцэтгэсэн барилгын ажилд хамаарах байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, бэлгийн дарамт, хүүхдийн эсрэг хүчирхийллийн эрсдэлийг арилгах талаар нарийвчлан авч үзсэн ёс зүйн дүрмийг баталж, бүх ажилтнууддаа өгч гарын үсэг зуруулж мөрдүүлэх үүргийн талаар тусгана.

Е. Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ

1. Төслийн Бүрэлдэхүүн хэсэг 4 ("Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний талаарх бүрэлдэхүүн хэсэг")-ийн хүрээнд болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээг зохих ёсоор хэрэгжүүлэхийн тулд Зээлдэгч нь:
 - (a) Уг гарын авлагыг ("ХОБЭХХ-ны гарын авлага") Банканд хүлээн зөвшөөрөгдөхүйц хэлбэр, агуулгаар бэлтгэж, батлах бөгөөд үүнд Болзошгүй онцгой байдлын үед авах арга хэмжээг хэрэгжүүлэх (i) онцгой байдлын үед авах арга хэмжээний хэсгийг зохицуулах, хэрэгжүүлэх аливаа бүтэц буюу институцийн зохицуулалт; (ii) онцгой байдлын үед авах арга хэмжээний хэсэгт тусгаж болох тусгайлсан үйл ажиллагаа, үүнд шаардагдах зөвшөөрөгдөх зардал ("Онцгой байдлын үеийн зардал") болон түүнийг оруулах аливаа журам; (iii) болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсгийн санхүүгийн менежментийн зохицуулалт; (iv) болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсгийн худалдан авах ажиллагааны арга, журам; (v) онцгой байдлын үеийн зардлыг санхүүжүүлэх Зээлийн хөрөнгийг гаргахад шаардагдах бичиг баримт; (vi) онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсгийн байгаль орчин, нийгмийн үнэлгээ, менежментийн зохицуулалтын тодорхойлолт; болон (vii) Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний загвар зэргийг нарийвчлан тусгана;
 - (b) Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөг Банк хүлээн зөвшөөрөхүйц хэлбэр, агуулгаар боловсруулж батална;
 - (c) Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ "ХОБЭХХ-ны гарын авлага" болон Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлэх бөгөөд ингэхдээ "ХОБЭХХ-ны гарын авлага" эсвэл Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө болон энэхүү Хэлэлцээр хоорондоо зөрчилдсөн тохиолдолд энэхүү хэлэлцээрийн заалтыг дагаж мөрднө;
 - (d) Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр "ХОБЭХХ-ны гарын авлага" болон Онцгой байдлын үед хариу авах арга хэмжээний



төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулахгүй, түдгэлзүүлэхгүй, цуцлахгүй, хүчингүй болгохгүй, хэрэгжүүлэхээс зайлсхийхгүй.

2. Зээлдэгч нь онцгой байдлын үеийн хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх үедээ “ХОБЭХХ-ны гарын авлага”-д тусгагдсан бүтэц, зохион байгуулалтыг хадгалж Банкны шаардлагыг хангахуйц ажилтнууд болон нөөцөөр хангана.
3. Зээлдэгч нь дараа шаардлагыг хангасан байна:
 - (a) онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсэгт шаардагдах байгаль орчин, нийгмийн арга хэрэгслийг ХОБЭХХ-ны гарын авлага болон БОНХТ-ний дагуу Банкны хүлээн зөвшөөрөхүйц хэлбэр, агуулгаар бэлтгэж, ил тод болгож, баталсан байх;
 - (b) болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсэг нь байгаль орчин, нийгмийн арга хэрэгслийн дагуу Банканд хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар хийгдсэн байх явдлыг баталгаажуулна.
4. Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсгийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг гагцхүү Зөвшөөрөгдөхүйц онцгой байдал эсвэл хямрал үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлнэ.

Хэсэг II. Төслийн Хяналт-шинжилгээ, Тайлагнал ба Үнэлгээ

A. Төслийн тайлан

Зээлдэгч нь төслийн улирлын тайланг тухайн улирал дууссанаас хойш дөчин тав (45) хоногт багтаан Банканд ирүүлнэ.

B. Дунд-хугацааны үнэлгээ

Зээлдэгч нь: (a) Төсөл хүчин төгөлдөр болсноос хойш хорин дөрвөн (24) сарын дараа, тайланг хугацаанд Төслийг хэрэгжүүлэх явцад гарсан ахиц дэвшилийг Банкны үндэслэл бүхий хүсэлтийн дагуу аль болох нарийвчлан тусгаж баримтжуулсан, энэхүү А хэсгийн дагуу гүйцэтгэсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг харгалзан үзсэн, мөн Төслийг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлэх, төслийн зорилгыг ханган биелүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тодорхойлон тусгасан дунд хугацааны тайланг бэлтгэж Банканд хүргүүлнэ; (b) Дунд-хугацааны тайланг хүргүүлснээс хойш дөчин тав (45) хоногт багтаан тайланг Банктай хамт хянаж үзэх ба дунд хугацааны тайлангийн дүгнэлт, зөвлөмж, энэ талаарх Банкны үнэлэлтэд үндэслэн Төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх, зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авна.

Хэсэг III. Зээлийн хөрөнгийг татаж авах

A. Ерөнхий зүйл.

Зээлдэгч нь Ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлийн заалтуудаар хязгаарлахгүйгээр, Зарцуулалт ба Санхүүгийн мэдээллийн захидлын дагуу (a) Зөвшөөрөгдөх зардлыг санхүүжүүлэх; (б) (i) Зээлийн үйлчилгээний хураамж болон (ii) Хүүний дээд хязгаар буюу хүүний дээд, доод хязгаарын баталгааны шимтгэлийг хуваарилсан хэмжээгээр, хэрэв боломжтой бол дараах хүснэгтийн

28 08 28

Ангилал тус бүрд заасан хувь хүртэлх хэмжээгээр төлөх зорилгоор Зээлийн хөрөнгийг татан авч болно.

Ангилал	Хуваарилагдсан зээлийн хэмжээ (ам. доллароор)	Санхүүжүүлэх зардлын хувь (татвар ороод)
(1) Бараа, ажил, зөвлөхийн бус болон зөвлөхийн үйлчилгээ, үйл ажиллагааны зардал, төслийн сургалтууд	99,750,000	100%
(2) Онцгой байдлын үеийн зардал	0	100%
(3) Үйлчилгээний хураамж	250,000	Ерөнхий нөхцөлийн 2.07 (b) хэсгийг үндэслэн энэхүү Хэлэлцээрийн 2.03-т заасны дагуу төлөх төлбөрийн дүн
(4) Хүүний дээд хязгаар буюу хүүний дээд, доод хязгаарын баталгааны шимтгэл	0	Ерөнхий нөхцөлийн 4.05 (c) хэсгийн дагуу төлөх дүн
НИЙТ ДҮН	100,000,000	

В. Санхүүжилт татан авах нөхцөл, хугацаа.

1. Дээрх А хэсгийн заалтыг үл харгалзан, дараах зардлыг санхүүжүүлэхэд зориулж санхүүжилт татахгүй:

- (a) 2021 оны 7-р сарын 1-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хийсэн Ангилал (1)-д хамаарах зөвшөөрөгдөх зардалд зориулж татан авсан нийт дүнгээр хорин сая доллар (20,000,000 ам. доллар)-аас хэтрэхгүй хэмжээний төлбөрөөс бусад Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс өмнө хийсэн төлбөр; эсвэл
- (b) Ангилал (2) -т хамаарах онцгой байдлын үеийн зардлын тухайд, хэрэв дээрх зардлын хувьд дараах бүх нөхцөл хангагдаагүй бол:
 - (i) (A) Зээлдэгч нь Онцгой гэж зөвшөөрөгдөхүйц нөхцөл байдал, хямрал үүссэнийг тогтоож, дээрх хүснэгт дэх Ангилал (2)-т заасан зээлийн хөрөнгийг татаж авах хүсэлтээ Банканд хүргүүлсэн; (B) Банк үүнтэй санал нийлж, уг хүсэлтийг хүлээн авч, энэ тухай Зээлдэгчид мэдэгдсэн;
 - (ii) Зээлдэгч нь Банк хүлээн зөвшөөрөхүйц хэлбэр, агуулгатай "ХОБЭХХ-ны гарын авлага" болон Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөг баталсан.

2. Хаагдах хугацаа 2028 оны 5 дугаар сарын 1-ний өдөр байна.



ХУВААРЬ 3

Хүлээсэн үүрэгтэй холбоотой элэгдлийн эргэн төлөлтийн хуваарь

Дараах хүснэгтэд Зээлийн үндсэн төлбөрийг эргэн төлөх хугацаа болон үндсэн төлбөр төлөх хугацаа тус бүрд ногдох зээлийн үндсэн дүнгийн нийт төлбөрийн хувийг ("Төлбөрийн хувь") харуулав.

Үндсэн төлбөрийн эргэн төлөлт

Үндсэн төлбөр төлөх хугацаа	Хэсэгчилсэн төлбөрийн хувь
2027 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2052 оны 3 дугаар сарын 15-ны өдрийг дуустал жил бүрийн 3 дугаар сарын 15, 9 дүгээр сарын 15-ны өдөр	2%



ХАВСРАЛТ

Тодорхойлолт

1. “Аймаг” гэж Зээлдэгчийн нутаг дэвсгэрийн нэгж болох аймгийг; “аймгууд” гэж нэгээс (1) дээш тооны аймгийг хэлнэ.
2. “Жилийн ажлын төлөвлөгөө, төсөв” буюу “ЖАТТ” гэсэн товчлол нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын 1 дүгээр хэсэгт дурдсан төлөвлөгөө, төсвийг хэлэх бөгөөд тухайн төлөвлөгөөнд Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр өөрчлөлт оруулж болно.
3. “Авлигатай тэмцэх удирдамж” гэж Ерөнхий нөхцөлийн Хавсралтын 6 дахь хэсэгт заасан зорилгын үүднээс, 2006 оны 10 дугаар сарын 15-ны өдөр баталж, 2011 оны 1 дүгээр сард шинэчилсэн, 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн байдлаарх “ОУСБХБ-ны зээл болон ОУХА-ийн зээл, буцалтгүй тусламжаар санхүүжүүлж буй төслүүдэд залилан мэхлэлт, авлигын асуудал гарахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх удирдамж”-ийг хэлнэ.
4. “Ангилал” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын 3.А дугаар хэсэг дэх хүснэгтэд заасан ангиллыг хэлнэ.
5. “ХОБЭХХ-ны гарын авлага” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.E хэсэгт дурдсан гарын авлагыг хэлэх бөгөөд Төслийн үйл ажиллагааны гарын авлагын салшгүй хэсэг болох уг гарын авлагыг Банктай тохиролцсоны үндсэн дээр үе үе шинэчилж болно.
6. “Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ” гэж Төслийн Бүрэлдэхүүн хэсэг 4-ийг үндэслэн онцгой гэж зөвшөөрөгдөхүйц нөхцөл байдал, хямралын үед хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагааг хэлнэ.
7. “Онцгой гэж зөвшөөрөгдөхүйц нөхцөл байдал, хямрал” гэдэг нь Зээлдэгчийн эдийн засаг болон/эсвэл нийгэмд томоохон сөрөг нөлөөлөл үзүүлсэн, эсвэл ойрын хугацаанд үзүүлж болзошгүй, байгалийн болон/эсвэл хүний үйл ажиллагаанаас үүдсэн хямрал, гамшигтай холбоотой үзэгдлийг хэлнэ.
8. “Онцгой байдлын үеийн зардал” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.E хэсэгт заасны дагуу “ХОБЭХХ-ны гарын авлага”-д тусгасан Болзошгүй онцгой байдлын үед хариу арга хэмжээ авахад шаардагдах аливаа зөвшөөрөгдөх зардлыг хэлнэ.
9. “Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө” гэж I.E хэсэгт заасан үйл ажиллагаа, төсөв, үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө, хяналт-шинжилгээ, үнэлгээний зохицуулалтыг нарийвчлан тусгасан, зөвшөөрөгдөхүйц онцгой байдал, хямралын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэлнэ.
10. “Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө” буюу “БОНХТ” гэж Төслийн 2023 оны 06 дугаар сар Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөөг хэлэх бөгөөд үүнд энэхүү Хэлэлцээрт заасны дагуу Төслийн үзүүлэх байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэл, нөлөөллийг арилгахад чиглэсэн арга хэмжээ, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, зохион байгуулалт, хүн хүч, сургалт, хяналт, тайлагналын зохицуулалт, тэдгээрийн дагуу бэлтгэх байгаль орчин,

нийгмийн арга хэрэгсэл зэргийг багтаасан Зээлдэгчийн зүгээс хэрэгжүүлэх шаардлагатай эсвэл хэрэгжүүлэхэд хүрэх материаллаг арга хэмжээ болон үйл ажиллагааг тодорхойлсон нэмэлт өөрчлөлт оруулж болно.

